



АРХАНГАЙ АЙМГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

## АРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2018/11



[www.nso.mn](http://www.nso.mn) [www.arkhangai.nso.mn](http://www.arkhangai.nso.mn) [www.1212.mn](http://www.1212.mn)




## ЭРҮҮЛ МЭНД

Эмнэлгийн байгууллагууд 518 ор, амбулаторийн 111 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 283.2 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 105.5 мянгад нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж 18.9 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна.

Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 99.1 хувийг бүрэн хамруулсны дотор Ихтамир, Хайрхан, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Цахир сумд 100,0 хувь хамруулсан байна.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 11 сарын байдлаар



Оны эхний 11 сард 1592 эхээс 1593 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оныхоос 10.3 хувиар буюу 181 хүүхдээр бага байна.

Хүн амын нас баралт 480 гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 67 тохиолдлоор буюу 16.7 хувиар их байна. Мянган хүнд ноогдох төрөлт 16.8, нас баралт 5.1 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 11.7 промил байна. Оны эхний 11 сард эхийн эндэгдэл 1 гарсан, нэгээс тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 10 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 42.8 хувиар их байна.

Нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 30 гарч мянган амьд төрөлтөд 18.8 ногдож байгаа нь өнгөрсөн оныхоос 1 тохиолдлоор буурсан байна.



Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 53 нь буюу 501 хүн халдварт өвчнөөр өвчилсөн байгаа бөгөөд Эрдэнэбулган(87), Батцэнгэл (82), Ихтамир (78), Жаргалант (63) сумдад аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 17.9 хувь нь салхин цэцгээр, 12.8 хувь нь цусан суулга, 47.5 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 11.4 хувь нь сүрьеэгээр, 10.4 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Өнгөрсөн оныхоос халдварт өвчний гаралт 14.4 хувиар буюу 63 тохиолдлоор өссөн байна.



## **АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР**


12 дугаар сарын 1-ний байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 929 ажилгүй хүн байгаагийн 50.1 хувь нь буюу 465 нь

эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны 10.0 мянган хүн тутамд 166 ажилгүйчүүд ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 33.9 хувиар буурсан байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 99.0 хувь нь боловсролтой иргэд байгаагийн 136 нь дээд, 40 нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 705 нь бүрэн болон бүрэн бус дунд, 39 нь бага боловсролтой хүмүүс байна.

11 дүгээр сард ажилгүйчүүдийн бүртгэлд 347 хүн шинээр бүртгүүлж, 312 хүн ажил идэвхитэй хайхаа больсноос идэвхигүй болсон байна. Харин 138 хүн ажилд зуучлуулан орсон байна.

Оны эхний 11 сард аймгийн дүнгээр 1109 ажлын байр шинээр бий болгосон байна. Шинэ ажлын байрыг сумдаар үзвэл Эрдэнэбулган сум 392, Эрдэнэмандал, Өндөр-улаан, Тариат сумд 68-78 ажлын байрыг, Булган, Ихтамир, Өлзийт, Цэнхэр, Цэцэрлэг, Чулуут, Хашаат сумд 51-45 ажлын байрыг, Өгийнуур, Тариат, Батцэнгэл, Хангай, Жаргалант, Цахир, Хайрхан, Төвшрүүлэх сумууд 10-39 ажлын байрыг тус тус бий болгожээ.

### Ажлын шинэ байранд ажилд орсон иргэний тоо





## НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 11 сард 47.0 тэрбум төг, зарлага 46.2 тэрбум төг болж өмнөх оныхоос орлого 3128.2 сая төг буюу 7.1 хувиар, зарлага 3170.7 сая төг буюу 7.4 хувиар өслөө.


Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 3128.2 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 14.7 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оныхоос 7.4 хувиар өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 14.6 хувиар өссөн нь нөлөөлөв. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт 32.3 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэмжид 1487.5 сая төгрөгийг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс олгосон тэтгэврийн хэмжээ 14.6 хувиар, тэтгэмжийн хэмжээ 5.6 хувиар өссөн байна.

Оны эхний 11 сард нийгмийн халамжийн сан болон хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 22.8 мянган хүнд 12447.3 сая төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт тусламж, хишиг олгосон байна. Нийгмийн халамж үйлчилгээгээр олгосон нийт мөнгөний 48.6 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгосон халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт 47.8 хувийг улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж эзэлж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон мөнгөний 52.0 хувийг халамжийн тэтгэврээр, 28.1 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжээр, 19.9 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон болон хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид зарцуулж байна.

### Нийгмийн халамжийн сангаас олгосон, тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц




### ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээгээр 279 холбогдогч бүхий 493 гэмт хэрэг гарсны дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 169, өмчлөх эрхийн эсрэг 241, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 38, байгаль хамгаалах журмын эсрэг 15, бусад 30 хэрэг гарсан байна.


Гэмт хэргийн улмаас 23 хүн нас барж, 206 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 1207.5 сая төгрөгийн хохирол учирсан байна. Бүртгэгдсэн нийт хэргийн 8.9 хувийг бүлэглэж 15.6 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 531 хүнийг албадан саатуулж 202 хүнийг баривчилсан байна.

**Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдогчийн тоо, жил бүрийн эхний 11 сарын байдлаар**



Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 1.0 хувиар буюу 5 тохиолдлоор нэмэгдсэний дотор хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 3.7 хувиар нэмэгдэж харин өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 1.2 хувиар буурсан байна.

**Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 11 сарын байдлаар**






## ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГА

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2018 оны эхний 11 сард аймгийн төсөвт 17146.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 21594.9 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 125.9 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 6008.3 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 7324.3 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 121.9 хувиар биелүүллээ. Төсвийн орлогын төлөвлөгөөг Ихтамир, Хангай, Тариат, Өндөрүлаан, Эрдэнэмандал, Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Өлзийт, Өгийнуур, Хашаат, Батцэнгэл, Цэнхэр, Хотонт, Эрдэнэбулган, Цахир, Чулуут сумд 108.6 хувиас 3.9 дахин биелүүлсэн байна. Харин Төвшрүүлэх сум 25.9 хувиар тасалсан байна.

Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, хувиар



Орлогыг нэр төрлөөр нь үзвэл бууны татвар, ойгоос мод түлээ ашигласны төлбөрөөс бусад нэрийн орлогуудыг 106.5 хувиас - 4.8 дахин биелүүлсэн байна.




Аймгийн төсвийн орлогын 66.1 хувийг тусламжийн орлогоор, 28.9 хувийг орлогын албан татвараар, 1.0 хувийг өмчийн татвараар, 1.4 хувийг тусгай зориулалтын орлогоор /АТӨЯХэрэгслийн/, 5.3 хувийг бусад албан татвараар, 3.4 хувийг татварын бус орлогоор бүрдүүлж байна.

Улсын төвлөрсөн төсөвт аж ахуй нэгжийн орлогын татвараар 252.8 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 910.1 сая төгрөг, агаарын бохирдлын төлбөрөөр 26.4 сая төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр 577.4 сая төгрөг, бүгд 1766.8 сая төгрөгийг шилжүүлж төлөвлөгөөг 169.9 хувиар биелүүлэв..

Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлагын хэмжээ 59166.1 сая төгрөг байгаагийн 46.5 хувийг цалин хөлсөнд, 5.7 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 47.8 хувийг бараа үйлчилгээ болон бусад зардалд зарцуулжээ. Эдийн засгийн салбараар харвал 40.7 хувийг нийтийн ерөнхий үйлчилгээнд, 48.9 хувийг боловсролын салбарт, 9.4 хувийг эрүүл мэндийн салбарт, 0.6 хувийг барилга хот байгуулалтын салбарт, 0.4 хувийг бусад салбарт зарцууллаа.

**Орон нутгийн төсвийн байгууллагын  
нийт зарлагын бүтэц, хувиар**





## МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Манай аймагт арилжааны 4 банкны салбар иргэд аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Монгол банкны архангай аймаг дахь салбарын мэдээгээр арилжааны банкууд монгол банкнаас зузаатгалаар 21.8 тэрбум төгрөгийг авч 26.5 тэрбум төгрөгийг гүйлгээнээс эргүүлэн татсан байна. Оны эхний 11 сард банкууд 57.2 мянган иргэд, аж ахуй нэгжид 134.9 тэрбум төгрөгийн зээл олгосны дотор 37 хүнд 1205.3 сая төгрөгийн орон сууцны зээл олгосон байна.

Өнгөрсөн оны мөн үеийнхтэй зэрэгцүүлэхэд иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 26.2 хувиар, олгосон зээлийн хэмжээ 17.0 хувиар өсч харин анхаарал хандуулах зээлийн хэмжээ 0.1 хувиар буурч, чанаргүй зээлийн хэмжээ 22.0 хувиар нэмэгдсэн байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл, олгосон зээлийн хэмжээ, жил бүрийн эхний 11 сарын байдлаар сая.төг





## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2017 оны 11 дүгээр сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарынхаас 1.4 хувиар өнгөрсөн оны мөн үеийнхээс 7.4 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 10 дугаар сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан бараа үйлчилгээний үнэ тарифын 14.5 хувийнх нь өсч, 2.0 хувийнх нь үнэ буурч, 83.5 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Тухайлбал өмнөх сарынхаас жинсэн өмд, сармис, пенициллин, хөвөн, аяга, таваг угаагч шингэний үнэ 0.1 - 4.8 хувиар буурч харин адуу, үхрийн мах, байцаа манжин, бензин, дизелийн түлш, өвлийн гутал зэргийн үнэ 0.1 – 36 хувиар нэмэгдсэн байна,

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 32.3 хувийнх нь буюу 120 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 14.5 хувийнх нь буюу 54 нэрийн барааны үнэ буурч, 53.2 хувийнх нь үнэ тогтвортой байна.


Өнгөрсөн оны мөн үеийнхээс дотор мах, төмс, манжин, цемент, улаан лооль, ямааны мах, кетчуп, сонгино зэргийн үнэ 0.2 – 60.8 хувиар буурч, харин кабелийн телевизийн хураамж, бензин шатахууны үнэ, хуруу зай, үхрийн цул мах, , тамхи, хивс, усан үзэм, үзэм, эдийн саван зэрэг барааны үнэ 0.3 - 75 хувиар нэмэгдсэн байна.



## ХӨДӨӨ АЖ АХУЙ

11 дугаар сарын 1-ний байдлаар оны эхний хээлтэгч малын 80.8 хувь нь буюу 1794.1 мянган эх мал төллөж гарсан төлийн 93.1 хувь нь буюу 1669.9 мянган төл бойжиж байна. Төл бойжилтыг малын төрлөөр үзвэл гарсан ботгоны 88.9 хувь, унаганы 93.1 хувь, тугалын 94.1 хувь хурганы 94.4 хувь, ишигний 89.7 хувь нь бойжиж байна.

Сумдаас Чулуут, Төвшрүүлэх, Жаргалант, Тариат сумд гарсан төлөө 97.2 – 98.8 хувиар бойжуулж байна.




Өнгөрсөн оны мөн үеийнхээс аймгийн дүнгээр төллөсөн эх мал 3.9 хувиар, бойжиж байгаа төлийн тоо 6.8 хувиар бага, төлийн хорогдол 65.9 хувиар их байна.

Оны эхний мал 94.3 хувиар онд орж оны эхний малын 5.7 хувь буюу 299.5 мянган том мал хорогдов. Хорогдсон малын 10.3 хувийг адуу, 18.9 хувийг үхэр, 40.6 хувийг хонь, 30.2 хувийг ямааны хорогдол эзэлж байна.

Сумдаас Хотонт, Цэнхэр, Өгийнуур, Хашаат, Өлзийт, Батцэнгэл сумдын оны эхний малын 6.9- 13.6 хувь нь, Цахир, Хайрхан, Ихтамир, Төвшрүүлэх, Булган, Өндөрүлаан, Хангай, Эрдэнэбулган сумдын оны эхний малын 3.0- 5.5 хувь нь, бусад сумдын малын 0.3-2.7 хувь нь хорогдсон дүнтэй байна.

### Зүй бусаар хорогдсон малын тоо бүтэц, төрлөөр



Энэ хавар 6963.1 га-д үр тариа, 252.4 га-д төмс, 107.3 га-д хүнсний ногоо, 1750 га-д малын тэжээлийн ургамал, 1178 га-д техникийн ургамал тус тус тариалаад байна.

Өнгөрсөн оны энэ үеийнхтэй зэрэгцүүлэхэд үр тариа 9.7 хувиар, төмс 47.5 хувиар, техникийн ургамал 15.8 хувиар, хүнсний ногоо 39.2 хувиар, тэжээлийн ургамал 4.6 хувиар тус тус бага тариалсан байна.

Энэ онд аймгийн дүнгээр үр тариа 6549.5 тн, төмс 2113.7 тн, хүнсний ногоо 466.2 тн, тэжээлийн ургамал 5612.2 тн, техникийн ургамал 708.2 тонныг хурааж, байгалийн хадлан 70.5 мянган тн, гар тэжээл 985.1 тонныг бэлтгээд байна.

2018 онд манай аймаг ойгоос 96.6 мянган м3 галын түлээ, 11.1 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 107.7 мянган м3 мод авч ашиглахаар баталсанаас оны эхний 11 сард 65.5 мянган м3 галын түлээ, 9.9 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 75.3 мянган м3 мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн

модны гоожингийн орлогоор 232.5 сая төгрөг төсвийн орлогод оруулсан байна.




## АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд 2018 оны эхний 11 сард оны үнээр 5.6 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 5.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өнгөрсөн оныхоос 0.1 хувиар илүү байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 2122.1 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.9 хувиар илүү байна.

Нийт үйлдвэрлэлтийн 11.4 хувийг хүнс ундааны, 1.3 хувийг хэвлэлийн, 56.2 хувийг дулааны эрчим хүчний, 15.1 хувийг усан хангамж, 5.1 хувийг модон эдлэлийн, 6.8 хувийг гутал хувцасны, 4.1 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлснээр гол нэрийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, бууз, савласан цэвэр ус, түгээсэн цэвэр ус, савхин гутал, дээл, вакуум цонх үйлдвэрлэлт 101.8 хувиас 2.0 дахин өссөн байна.. Харин, хэрчсэн гурил, монгол гутал, дулаан , хүрмэн блокны үйлдвэрлэлийн хэмжээ 0.9 – 40.7 хувиар буурсан байна.



Тээврийн байгууллагууд 54.6 мянган зорчигч, 48.4 мянган тонн ачаа тээвэрлэн 23.5 сая хүн км, 6.6 сая ткм ажил гүйцэтгэн 537.3 сая төгрөгийн орлоготой ажиллаа. Өнгөрсөн оны мөн үеийнхээс зорчигч, зорчигч эргэлт, ачаа эргэлт, орлогын хэмжээ 0.8 -10.6 хувиар буурсан байна.

Холбооны байгууллагууд 402 телефон цэг улс, хот хоорондын телефон, интернет, телевизийн үйлчилгээгээр байгууллага иргэдэд үйлчилж сумдад 7 хоногт 1-2 удаа шуудан хүргэж нийт 278.5 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.5 хувиар буурсан байна.



## ЦАГ УУРЫН БАЙДАЛ

11 дүгээр сард агаарын дундаж температур – 7.0-өөс -11.4 хэм байсан бөгөөд хамгийн их дулаан Чулуут, Батцэнгэл, Хашаат, Эрдэнэмандал, Төвшрүүлэх, Хотонт, Эрдэнэбулган сумдад 9.0-ээс 13.0 хэм хүрч байсан бол хамгийн хүйтэн нь Өндөрүлаан, Хангай, Цахир, Чулуут, Булган сумдад –24.0-аас –30.0 хэмд хүрч хүйтэн байсан байна.

11 дүгээр сард Эрдэнэбулган, Булган, Төвшрүүлэх сумдын нутгаар 5.1 - 9.2 мм тундас орсон нь хамгийн их тундастай байгаа бол Цахир, Эрдэнэмандал сумдад цас ороогүй Хангай, Тариат, Цэцэрлэг, Хайрхан, Өлзийт, Батцэнгэл, Хотонт сумдад 0.2 - 1.3 мм хур тундас орсон нь хамгийн бага байна.

**Статистикийн хэлтэс**  
**2018.12.11**